СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛСТИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Н.ДАШДОНДОВЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН АЖИЛТНЫ ТӨГСӨЛТИЙН ДАРААХ ТАСРАЛТГҮЙ СУРГАЛТЫН БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТИЙН НЭГДСЭН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЗОХИЦУУЛАЛТ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын 2025-2026 оны элсэлтийн хяналтын тоог чиглэл бүрээр тодорхойлж, хянаж батлуулах | Эрүүл мэндийн сайдын хяналтын тооны батлагдсан тушаал | Эрүүл мэндийн сайдын 2024-2025 оны хяналтын тооны баталсан тушаал | 2025-2026 оны хичээлийн жилийн төгсөлтийн дараах сургалтын хяналтын тоо, чиглэлийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна. | Эмнэлгийн мэргэжилтний 2025-2026 оны төгсөлтийн дараах элсэлтийн хяналтын тоо, сургалтын чиглэлийг тодорхойлж Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн “Эрүүл мэндийн ажилтны 2025-2026 оны төгсөлтийн дараах сургалтын чиглэл, элсэлтийн хяналтын тоо, сургалтын зардал батлах тухай” А/156 дугаар тушаалаар батлуулсан. | 2025.01.01-2025.06.30 | 100 |
| | Дэд арга хэмжээ. 1.1.1: Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын 2025-2026 оны элсэлтийн хяналтын тоог хянах | Үндсэн арга хэмжээний эзлэх хувь | Үндсэн арга хэмжээний 50% хэрэгжилт | Эрүүл мэндийн хөгжлийн төв, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулиас 2025-2026 оны элсэлтийн хяналтын тоог | Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын 2025-2026 оны элсэлтийн хяналтын тооны саналыг Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс 2025 оны 05 дугаар сарын 27-ний өдрийн 311, Анагаахын шинжлэх ухааны үндэсний сургуулиас 2024 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 04/59 дугаар албан бичгээр тус тус авч хянасан. | 2025.01.01-2025.02.28 | 50 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | авч хянасан байна. | | | |
| | Дэд арга хэмжээ. 1.1.2: Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын 2025-2026 оны элсэлтийн хяналтын тооны тушаалын төсөл боловсруулж, батлуулах | Үндсэн арга хэмжээний эзлэх хувь | Үндсэн арга хэмжээний 50% хэрэгжилт | 2025-2026 оны элсэлтийн хяналтын тоог Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна. | Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын 2025-2026 оны элсэлтийн хяналтын тооны тушаалыг эрүүл мэндийн байгууллагын захиалга, хэрэгцээ шаардлагыг үндэслэж төслийг боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн “Эрүүл мэндийн ажилтны 2025-2026 оны төгсөлтийн дараах сургалтын чиглэл, элсэлтийн хяналтын тоо, сургалтын зардал батлах тухай” А/156 дугаар тушаалаар батлуулсан. | 2025.02.01-2025.06.30 | 50 |
| 2. | Арга хэмжээ 1.2. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллагыг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт байгуулах | Шинээр төгсөлтийн дараах сургалт эрхлэх зөвшөөрөл авсан аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн тоо | Төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллага 2023 онд шинээр 2 байгуулагдсан байна. | Төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллага аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт 1 байгуулагдсан байна. | Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар тогтоолоор УХТЭ-т Мэдээгүйжүүлэг судлал, Ач АУИС-ийн харьяа Ач интернэйшнл эмнэлэгт Мэс засал, дотор, Нүүр ам судлал, Төмөр замын Нэгдсэн эмнэлэгт Ерөнхий мэргэшил судлал, АШУҮИС-ийн харьяа Монгол-Япон эмнэлэгт Гэмтэл согог судлалын чиглэлээр сургалт эрхлэх зөвшөөрөл тус тус шинээр олгосон. | 2025.01.02-2025.06.30 | 100 |
| **Зорилт 2. “ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ТӨГСӨЛТИЙН ДАРААХ СУРГАЛТЫН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ, ИНДЕКСИЙГ ТОДОРХОЙЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЗОХИЦУУЛАЛТ”** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, | Эрүүл мэндийн сайдын батлагдсан тушаал | Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 тушаалаар | Журмын төслийг шинэчлэн боловсруулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/204 дүгээр тушаалаар төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог шинэчлэх ажлын хэсэг байгуулагдсан.Уг ажлын хэсгийн хзрээнд “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, | 2025.01.02-2025.06.30 | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”-ыг шинэчлэн боловсруулж, батлуулах | | зохицуулж байна. | | сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”-ыг шинэчлэн боловсруулсан. | | |
| 2. | Арга хэмжээ 2.2. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн батлуулах | Шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хөтөлбөр | 2023 онд шинээр 2 хөтөлбөр шинэчлэгдэн батлагдсан. | Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөр 2 хөтөлбөрийг шинээр болон шинэчлэн батлуулсан байна. | Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор Үндсэн мэргэшлийн сургалтын Нүүр амны согог засал судлал, Шүдний ерөнхий эмчилгээ судлал, Шүдний тулгуур эд судлал, Нүүр амны мэс засал судлал, Хүүхдийн нүүр ам судлалын чиглэл. Төрөлжсөн мэргэшлийн сургалтын Настны сувилахуй, Хавдрын туяа эмчилгээ, Хавдрын хими эмчилгээ судлал, Эмэгтэйчүүдийн хавдар судлал, Насанд хүрэгчдийн сувилахуй/ Дотрын сувилахуй чиглэлийг хөтөлбөрийг шинэчилж баталсан. Мөн Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 02 дугаар тогтоолоор төрөлжсөн мэргэшлийн сургалтын Харвалт, тархины судасны эмгэг судлалын хөтөлбөрийг шинээр баталсан. | 2025.01.02-2025.06.30 | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 3. | Арга хэмжээ 2.3. Төгсөлтийн дараах сургалтын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж батлуулах | Төгсөлтийн дараах сургалтын тэргүүлэх чиглэлийн батлагдсан тушаал | - | Төгсөлтийн дараах сургалтын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох нөхцөл байдлын судалгаа хийсэн байна. | Төгсөлтийн дараах сургалтын тэргүүлэх чиглэлийг хүн амын нас баралт, өвчлөл, хэрэгцээнд тулгуурлан Сэргээн засах, Эрчимт эмчилгээ, Хавдар, Хүүхэд, Гэмтэл согог, Яаралтай тусламж, Дүрс оношилгоо, Мэс засал, Сэтгэц, Чих хамар хоолой судлалын чиглэлээр аймаг, нийслэл тус бүрээр Эрүүл мэндийн даатгалын сангаар санхүүжилт авсан тохиолдлын тоо, эрүүл мэндийн даатгалын сангаар санхүүжилт авч буй эмчийн тоо, Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн санд бүртгэлтэй эмнэлгийн мэргэжилтний тоо, тухайн орон нутаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа хүний нөөцийн мэдээллийг утсаар болон албан бичгээр авч боловсруулалт хийн нөхцөл байдлын судалгааг хийсэн. | 2025.01.02-2025.06.30 | 70 |
| **Зорилт 3. “ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ, МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН НЭГДСЭН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЗОХИЦУУЛАЛТ”** | | | | | | | |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 3.1. Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж ажиллах | Зохион байгуулагдсан хурлын тоо, батлагдсан тушаалын тоо | 2024 онд 11 тушаал батлуулсан. | Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн нарийн бичгийн даргын үүрэгт ажлыг гүйцэтгэж, холбогдох тушаал шийдвэрийг тухай бүр батлуулсан байна. | Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөл нь 2025 оны эхний хагас жилд нийт 5 удаа хурал зохион байгуулж, анх удаа зөвшөөрөл хүссэн 97 гадаадын эмнэлгийн мэргэжилтний асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Эрүүл мэндийн сайдын 7 удаагийн тушаалаар анх удаа болон давтан нийт 169 гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн зөвшөөрлийг олгосон. Мөн төгсөлтийн дараах сургалтын багц цаг бүрдүүлсэн болон мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад тэнцсэн 4,079 эмнэлгийн мэргэжилтний бичиг баримтыг хянаж Эрүүл мэндийн сайдын 5 удаагийн тушаалаар олгож, Шүүхийн шийдвэрийн дагуу 2 эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийг Эрүүл мэндийн сайдын 2 удаагийн тушаалаар хүчингүй болгосон. | 2025.01.02-2025.06.30 | 100 |
| 2 | Арга хэмжээ 3.2. “Мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам”-ыг шинэчлэн боловсруулж, батлуулах | Эрүүл мэндийн сайдын батлагдсан тушаал | Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/513, 2023 оны А/217 тушаалаар зохицуулж байна. | Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/57 дугаар тушаалаар “Мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам”-ыг шинэчлэн батлуулсан. | 2025.02.01-2025.06.30 | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 4. “ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАСРАЛТГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 4.1. Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлуулах | Эрүүл мэндийн сайдын батлагдсан тушаал | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/618 тушаал | Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/98 дугаар тушаалаар Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлуулсан. | 2025.01.02-2025.06.30 | 100 |
| 2. | Арга хэмжээ 4.2. Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлуулах | Эрүүл мэндийн сайдын батлагдсан тушаал | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/280 тушаал | Эрүүл мэндийн сайдын тушаалын төслийг боловсруулсан байна. | Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлуулахаар Эрүүл мэндийн сайдын тушаалын төслийг боловсруулж, газар хэлтсийн дарга нарт танилцуулж байна. | 2025.01.02-2025.06.30 | 100 |
| 3. | Арга хэмжээ 4.3. Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж ажиллах | Хянасан тушаалын тоо, батлагдсан тушаал | 2024 онд төгсөлтийн дараах сургалтын чиглэлээр 5, Мэргэшлийн чиглэлээр 1 тушаалыг батлуулсан. | Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн нарийн бичгийн даргын үүрэгт ажлыг гүйцэтгэж, холбогдох тушаал шийдвэрийг тухай бүр | Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 тогтоолоор Үндсэн мэргэшлийн сургалтын Нүүр амны согог засал судлал, Шүдний ерөнхий эмчилгээ судлал, Шүдний тулгуур эд судлал, Нүүр амны мэс засал судлал, Хүүхдийн нүүр ам судлалын чиглэл. Төрөлжсөн мэргэшлийн сургалтын Настны сувилахуй, Хавдрын туяа эмчилгээ, Хавдрын хими эмчилгээ судлал, Эмэгтэйчүүдийн хавдар судлал, Насанд хүрэгчдийн | 2025.01.02-2025.06.30 | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | батлуулсан байна. | сувилахуй/ Дотрын сувилахуй чиглэлийг хөтөлбөрийг шинэчилж баталсан.<br><br>Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 02 тогтоолоор төгсөлтийн дараах сургалт эрхлэх УХТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, АШУҮИС-ийн Монгол-Япон эмнэлэг, Орхон БОЭТ, Нийслэлийн Амгалан амаржих газар, Оточ манрамба их сургуулийн эмнэлэг зэрэг нийт 7 байгууллагын хугацааг сунгаж, Ач интернейшнл эмнэлэг, Төмөр замын Нэгдсэн эмнэлэг, УХТЭ, АШУҮИС-ийн Монгол-Япон эмнэлэг нийт 4 байгуулагад шинээр олгож, Төрөлжсөн мэргэшлийн сургалтын Харвалт, тархины судасны эмгэг судлал хөтөлбөрийг шинээр баталж шийдвэрлэсэн. | | |
| **Зорилт 5. “ЭРҮҮЛ МЭНД, АНАГААХ УХААНЫ ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭХ, МЭРГЭШҮҮЛЭХ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, КАРЬЕРЫН ЗУРАГЛАЛЫГ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЗОХИЦУУЛАЛТ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | ЗГҮАХ 2.3.4.1<br>Арга хэмжээ 5.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг гадаад улсад урт, богино хугацааны сургалтад багаар хамруулах | Сургалтад хамрагдсан багийн тоо | 2024 онд 8 баг хамрагдсан байна. | 6 баг хамрагдсан байна. | -Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй өвчин эмгэгийг бууруулах зорилгоор Хүзүү сээр, бүсэлхий нурууны төрөлхийн хүнд хэлбэрийн муруйлт эмгэгийн мэс заслын чиглэлээр ГССҮТ-ийн 2 мэс заслын эмч, 1 мэдээгүйжүүлгийн эмчийг БНСУ-ын Сунчинхян их сургуулийн Бучён эмнэлэг, Кореа Их сургуулийн Ансан эмнэлэгт 2025 оны 01 дүгээр сарын 17-ний өдрөөс эхлэн 1 жилийн хугацаагаар, Хүүхдийн хавсарсан хөх, хэлбэрийн зүрхний төрөлхийн гажгийн | 2025.01.02-2025.06.30 | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | үеийн мэс засал эмчилгээний чиглэлээр ЭХЭМҮТ-ийн 2 зүрхний мэс заслын эмч, 2 мэдээгүйжүүлгийн эмч, 1 эрчимт эмчилгээний эмч, 3 сувилагчийг БНХАУ-ын Фудан их сургуулийн Хүүхдийн эмнэлэгт 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс 6 сарын хугацаатай сургалтад хамруулж байна.<br><br>-Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг улсын хэмжээний жишиг амбулатори болох бэлтгэл ажлын хүрээнд БНСУ-ын Хюндай эмнэлэгт нийт 60 хүний 4 багийг Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, санхүүжилт, Эрүүл мэндийн байгууллагын удирдлага, менежмент, үйлчилгээний соёл, орчин үеийн чиг хандлага зэрэг чиглэлээр 2025 оны 01-05 дугаар сарын хооронд богино хугацааны сургалтад хамруулсан. | | |
| 2. | Арга хэмжээ 5.2. Анагаахын шинжлэх ухаан, технологийн дэвшил, инновацын тэргүүлэх чиглэлээр эмнэлгийн мэргэжилтэнг гадаадад урт хугацааны сургалтад хамруулах | Сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо | 2024 онд гадаадад урт хугацааны сургалтад 20 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. | 10 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. | 2025 оны эхний хагас жилд нийт **14** эмч, мэргэжилтнийг гадаад урт хугацааны сургалтад хамруулсан.<br><br>-БНХАУ-ын Нанжин хотын Зүүн өмнөд их сургуулийн Жунда эмнэлэгт Гэмтэл согог судлалын чиглэлээр ГССҮТ, ТТАХНЭ, ЦТЭ, Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлэг, Дорнод БОЭТ, СХДНЭ, Эрдэнэт Медипас эмнэлгийн нийт 12 эмчийг 2025 оны 05 дугаар сарын | 2025.01.02-2025.06.30 | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | 26-ын өдрөөс эхлэн 6 сарын хугацаатай урт хугацааны сургалтад хамруулж байна.<br><br>-Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн Эх барих, эмэгтэйчүүд судлал, Мэс засал судлалын чиглэлээр суралцаж буй 2-р дамжааны 2 резидент эмчийг БНСУ-ын “Олон Улсын боловсролын солилцооны нийгэмлэг”-тэй хамтран АНУ-д 2025 оны 06 дугаар сараас эхлэн 6 сарын хугацаатай урт хугацааны сургалтад хамруулж байна. | | |
| 3. | Арга хэмжээ 5.3. Гадаадын эмнэлгийн мэргэжилтнийг урьж ажиллуулан ажлын байранд ажиллан суралцах арга хэмжээг хэрэгжүүлэх | Ажиллан суралцах арга хэмжээнд хамрагдсан эмч, мэргэжилтний тоо | 2024 оны 80 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. | 50 эмч, мэргэжилтэн хамрагдсан байна. | 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 97 гадаадын эмнэлгийн мэргэжилтнийг урьж ажиллуулан ажлын байранд ажиллан суралцах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Нийт 42 эрүүл мэндийн байгууллагын 200 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг ажлын байранд дагалдуулан сургаж оношилгоо, эмчилгээний дараах хяналтыг хариуцаж ажиллахаар чадавхжуулсан байна. | 2025.01.02-2025.06.30 | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4. | Арга хэмжээ 5.4. Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2021-2025 оны батлагдсан чиглэлээр эмнэлгийн мэргэжилтнийг богино хугацааны гадаад сургалтад хамруулах | Гадаад сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо | 2024 онд гадаад богино хугацааны сургалтад 200 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан | 50 эмнэлгийн мэргэжилтэн гадаад сургалтад хамрагдсан байна. | 2025 оны эхний хагас жилд нийт **79** эмч, мэргэжилтнийг гадаад богино хугацааны сургалтад хамруулсан.<br><br>-Уламжлалт анагаах ухаан, Сэргээн засах эмчилгээ, Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдлын чиглэлээр БНХАУ-ын Хөх хотын ОУ-ын Монгол эмнэлэгт орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын нийт **59** эмнэлгийн мэргэжилтэнг 2 ээлжээр 2025 оны 04 сарын 11-26-ны өдрүүдийн хооронд богино хугацааны сургалтад хамруулсан.<br><br>-Удирдах ажилтныг чадавхжуулах эрүүл мэндийн салбарын шийдвэр гаргалт ба үр ашиг тооцолт чиглэлээр БНТУ, Сингапур улсын Үндэсний их сургууль, БНСУ-д ЭМХТ, ЭСҮТ, ЗӨСҮТ, СЭМҮТ, НЭМГ, БГДЭМТ-ийн **20** эмч, эмнэлгийн мэргэжилтэнг 2025 оны 01 дүгээр сарын 16-наас 05 дугаар сарын 30-ны хооронд богино хугацааны сургалтад хамруулсан. | 2025.01.02-2025.06.30 | 100 |
| 5. | Арга хэмжээ 5.5. Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн карьерын зураглал боловсруулж, батлуулах | Боловсруулагдсан карьерын зураглал | - | Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний карьер зураглал боловсруулагдсан байна. | Азийн хөгжлийн банкны “Монгол Улсад нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх техникийн туслалцааны төсөл”-ийн Хүний нөөцийн чиглэлийн зөвлөхүүдтэй 2 удаа уулзалтыг зохион байгуулсан. Тус уулзалтаар Эрүүл мэндийн сайдын 2012 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн 168 дугаар тушаалыг шинэчлэх, АНУ, Япон, БНСУ-ын нийгмийн эрүүл мэндийн | 2025.01.02-2025.06.30 | 30 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | мэргэжилтнүүдийн карьер зураглалыг судалсан судалгааг хэлэлцсэн. Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний карьер зураглалыг боловсруулан ажиллаж байна. | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Үүрэг даалгавар. Арга хэмжээ 1.1. Эрүүл мэндийн сайдын нэрэмжит 6 төрөл эрүүл мэндийн салбарын тэмцээнийг зохион байгуулах | - | - | Батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулах | Эрүүл мэндийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/53 дугаар тушаалаар Эрүүл мэндийн сайдын нэрэмжит 6 төрөлт спортын арга хэмжээг зохион байгуулах Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар томилогдсон. Тус спортын арга хэмжээний бэлтгэл ажлыг ханган 2025 оны 03 дугаар сарын 24-30-ны өдрүүдэд зохион байгуулан ажилласан. | 2025.02.01 2025.03.30 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1.1. Төрийн албаны | Сургалтад хамрагдсан | - | - | Удирдлагын академиас зохион байгуулсан төрийн албаны хаагчийг чиглүүлэх 40 цагийн | 2025.01.02-2025.06.30 | 70 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | мэргэшүүлэх богино болон дунд хугацааны сургалтад хамрагдана. | тоо, гэрчилгээ | | | богино хугацааны сургалтад 2025 оны 04 дүгээр сарын 21-24-ний өдрүүдэд хамрагдсан. | | |
| 2. | Арга хэмжээ 1.2. Анагаах ухаан чиглэлээр магистрын сургалтад хамрагдах | Магистрын сургалтын биелүүлсэн багц цаг | - | - | Хугацаа болоогүй. | 2025.06.30-2025.12.31 | - |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Мэргэжилтэн ..................... Н.Дашдондов ...................................... 2025.06.10

(Албан тушаал) (Нэр, гарын үсэг) (Огноо)